



МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙДЫН ТУШААЛ

2017 оны 04 сарын 13 өдөр

Дугаар А/87

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 142 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Хууль зүй, зүй дотоод хэргийн сайдын шагнал олгох журам"-ыг нэгдүгээр хавсралтаар, "Шагналд нэр дэвшигчийн тодорхойлолтын загвар"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2.Журмыг 2017 оны 04 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн мөрдөхийг Төрийн нарийн бичгийн дарга /Г.Баясгалан/-д даалгасугай.

3.Энэ тушаалаар Хууль зүйн сайдын 2013 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн А/73 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

С.БЯМБАЦОГТ

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН ШАГНАЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын болон хууль зүйн бусад салбарт онцгой амжилт гаргасан, мэргэжлээрээ тогтвортой, үр дүнтэй ажилласан төрийн албан хаагч, иргэнийг шагнаж урамшуулахад энэ журмыг баримтална.

Хоёр. Шагналын төрөл

2.1. Хууль зүй, дотоод хэргийн сайдын шагнал нь Засгийн газрын 2012 оны 142 дугаар тогтоолд заасны дагуу дор дурдсан төрөлтэй байна.

2.1.1. Засгийн газрын шагнал:

2.1.1.1 "Хууль зүйн албаны тэргүүний ажилтан" тэмдэг;

2.1.1.2 "Хүндэт хилчин" тэмдэг;

2.1.1.3 "Цагдаагийн алдар" тэмдэг;

2.1.1.4 "Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын тэргүүний ажилтан" тэмдэг;

2.1.1.5 "Улсын бүртгэлийн тэргүүний ажилтан" тэмдэг;

2.1.2. Хууль зүй, дотоод хэргийн яамны шагнал:

2.1.2.1 Яамны "Хүндэт жуух бичиг";

2.1.2.2 Мөнгөн шагнал;

Гурав. Шагнал олгох болзол

3.1. Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудал болон хууль зүйн салбарыг хөгжүүлэх, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хэрэгжүүлэх үйл хэрэгт тасралтгүй 15-аас доошгүй жил үр бүтээлтэй ажиллаж амжилтад хүрсэн, мэргэжлийн туршлага, өндөр үр чадвартай төрийн албан хаагч, иргэнийг "Хууль зүйн албаны тэргүүний ажилтан" тэмдгээр шагнана.

3.2. Хил хамгаалах байгууллагад 15-аас доошгүй жил үр бүтээлтэй ажиллаж, Улсын хил хамгаалах үйлсэд онцгой амжилт гаргасан хилчнийг "Хүндэт хилчин" тэмдгээр шагнана.

3.3. Гэмт хэрэгтэй тэмцэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам хамгаалах үүргээ үнэнч шударга, эрэлхэг зориг, авхаалж самбаа гарган нэр төртэй биелүүлсэн, эрхэлсэн ажилдаа онцгой гавьяа байгуулсан, амжилт гарган ажилласан цагдаагийн алба хаагч, чөлөөнд байгаа ахмадыг "Цагдаагийн алдар" тэмдгээр шагнана.

3.4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын салбарт 15-аас доошгүй жил үр бүтээлтэй ажилласан, үүрэг гүйцэтгэх хугацаандаа онцгой гавьяа байгуулсан, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд үнэтэй хувь нэмэр оруулсан албан хаагч, иргэнийг "Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын тэргүүний ажилтан" тэмдгээр шагнана.

3.5. Улсын бүртгэлийн байгууллагад 15-аас доошгүй жил ажилласан, улсын бүртгэлийн үйл ажиллагаанд үнэтэй хувь нэмэр оруулсан албан хаагч, иргэнийг "Улсын бүртгэлийн тэргүүний ажилтан" тэмдгээр шагнана.

3.6. Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудал болон хууль зүйн салбарт идэвх санаачлага, үр бүтээлтэй 10-аас доошгүй жил ажиллаж, ажил үйлсээрээ тэргүүлсэн, хууль боловсруулах, сурталчлах, хэрэгжүүлэх үйлсэд тодорхой үр бүтээл гаргасан төрийн албан хаагч, иргэнийг Хууль зүй, дотоод хэргийн яамны "Хүндэт жуух бичиг"-ээр шагнана.

3.7. Салбарын тэргүүний ажилтан, яамны шагналаар шагнахдаа дор дурдсан шалгуурыг харгалзан үзнэ. Үүнд:

- 3.7.1. Төрийн албанд тогтвор суурьшилтай ажилласан байдал;
- 3.7.2. Албан үүргээ тогтмол чанартай биелүүлж, идэвх санаачилга гаргасан байдал;
- 3.7.3. Төрийн албан хаагчийн мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээ, төрийн байгууллагын соёл, дэг журмыг сахиж буй байдал;
- 3.7.4. Ажил мэргэжлийн ур чадвар, мэргэшлийн түвшин;
- 3.7.5. Онцгой амжилт гаргасан, гавьяа байгуулсан;

3.8. Яамны зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх, хуулийн төсөл боловсруулах, хууль сурталчилах, салбарын бодлогыг хэрэгжүүлэх үйлсэд бодитой хувь нэмэр оруулж идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажилласан яамны албан хаагчийг хамт олны өмнө сайшааж 500.000 (таван зуун мянга) хүртэл төгрөгөөр шагнаж урамшуулна.

Дөрөв. Шагналд нэр дэвшүүлэх, тодорхойлох

4.1. Салбарын тэргүүний ажилтан тэмдэг, яамны шагналаар яамны газрын дарга, агентлагийн даргыг Төрийн нарийн бичгийн дарга, яамны ажилтан, албан хаагчийг тухайн газрын дарга, хамт олон, бусад яам, агентлаг, байгууллагын ажилтанг яам, агентлаг, байгууллагын дарга, бүх шатны шүүхийн шүүгч, шүүхийн байгууллагын ажилтныг Шүүхийн ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга, прокурорын байгууллагын ажилтныг Улсын ерөнхий прокурор, өмгөөлөгчдийг Монгол өмгөөлөгчдийн холбоо болон Монголын хуульчдын холбооны ерөнхийлөгч, нотариатчдыг Монголын нотариатчдын танхимын ерөнхийлөгч, аймаг, нийслэлийн

хууль зүйн хэлтсийн дарга, ажилтныг Засаг дарга нар тус тус шагнуулахаар нэр дэвшүүлнэ.

4.2. Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа агентлаг, байгууллагын орон нутаг дахь салбар нэгжийн ажилтанг агентлаг, байгууллагын дарга шагнуулахаар нэр дэвшүүлнэ.

4.3. Шагнуулахаар тодорхойлсон материал, холбогдох баримт бичгийг тухайн тэмдэглэлт өдөр, ой болохоос нэг сараас доошгүй хугацааны өмнө тус яаманд цахим болон цаасан хэлбэрээр ирүүлнэ. Шагналын материалыг хугацаа хожимдуулж ирүүлсэн, энэ журмын 4.4-д заасан материалыг дутуу ирүүлсэн тохиолдолд хүлээн авахгүй, тодорхойлолтыг тухайн байгууллагад нь энэ журамд заасан үндэслэлийн дагуу буцаана.

4.4. Шагнуулахаар нэр дэвшүүлсэн хүмүүсийг тодорхойлохдоо дор дурдсан материалыг бүрдүүлнэ:

4.4.1. Батлагдсан загварын анкет /гэрэл зураг 3x4/;

4.4.2. Ажил байдлын тодорхойлолт;

4.4.3. Шагнуулах тухай эрх бүхий албан тушаалтны гарын үсэгтэй албан бичиг;

4.4.4. Урьд шагнагдсан бол шийдвэрийн хуулбар;

4.4.5. Онцгой амжилт гаргасан бол түүнийг гэрчлэх баримт бичиг, шийдвэрийн хуулбар;

4.5. Шагналд нэр дэвшүүлсэн хүний ажил байдлын тодорхойлолт нь үнэн зөв, ажлын амжилт, авьяас чадвар, оруулсан хувь нэмрийг товч, тодорхой бичсэн байх бөгөөд холбогдох судалгаа, үзүүлэлтийг тусгасан байна.

4.6. Тус яамны харьяа агентлаг, байгууллага шагналын материалыг яамны холбогдох цахим санд оруулсаны дараа бичгээр ирүүлнэ.

4.7. Шагналыг Үндэсний их баяр наадам, Цагаан сар, Бүгд Найрамдах Улс тунхагласан өдрөөр болон Хуульчдын өдрөөр олгоно. Хууль зүй, дотоод хэргийн сайдын зөвшөөрснөөр бусад тохиолдолд шагнаж болно.

4.8. Шагнуулахаар тодорхойлсон материал, холбогдох баримт бичгийг тухайн тэмдэглэлт өдөр, ой болохоос нэг сараас доошгүй хугацааны өмнө тус яаманд цахим болон цаасан хэлбэрээр ирүүлнэ. Шагналын материалыг хугацаа хожимдуулж ирүүлсэн, энэ журмын 4.3, 4.4-д заасан материалыг дутуу ирүүлсэн тохиолдолд хүлээн авахгүй, тодорхойлолтыг тухайн байгууллагад нь энэ журамд заасан үндэслэлийн дагуу буцаана.

4.9. Өмнө авсан шагналаас хойш 5-аас доошгүй жил ажиллаж, ажлын амжилт бүтээл нь өмнөх түвшингээсээ ахисан тохиолдолд дараагийн шатны шагналд нэр дэвшүүлнэ. Онцгой амжилт гаргасан, тасралтгүй удаан жил, үр бүтээлтэй ажилласан тохиолдолд шагналыг хугацаанаас нь өмнө буюу алгасуулан олгож болно.

Тав. Шагналыг шийдвэрлэх

5.1. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын шагнал урамшууллын асуудал хариуцсан мэргэжилтэн холбогдох байгууллагаас шагнуулахаар нэр дэвшүүлсэн хүмүүсийн материалыг хүлээн авч хянана.

5.2. Шагнал урамшууллын асуудал хариуцсан мэргэжилтэн нь энэ журмын дагуу материалаа бүрдүүлж ирүүлсэн хүмүүсийн талаар санал боловсруулан яамны удирдлагад танилцуулна.

5.3. Шагнах асуудлыг Хууль зүй, дотоод хэргийн сайд тушаал гаргаж шийдвэрлэнэ.

5.4. "Хууль зүйн албаны тэргүүний ажилтан", "Хүндэт хилчин", "Цагдаагийн алдар", "Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын тэргүүний ажилтан", "Улсын бүртгэлийн тэргүүний ажилтан" тэмдэг болон "Хүндэт жуух бичиг"-ээр шагнагдагчдад хувийн дугаар бүхий үнэмлэх, гэрчилгээ олгоно.

5.5. Шагнагдсан хүмүүсийн тэмдэг, үнэмлэх болон шагналын тушаалын хуулбарыг тодорхойлсон байгууллагад хүлээлгэн өгнө.

5.6. Засгийн газрын "Хууль зүйн албаны тэргүүний ажилтан", "Хүндэт хилчин", "Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын тэргүүний ажилтан", "Цагдаагийн алдар", "Улсын бүртгэлийн тэргүүний ажилтан" тэмдгээр шагнахад 100 мянган төгрөг, "Жуух бичиг"-ээр шагнахад 50 мянган төгрөгийн мөнгөн шагнал тус тус дагалдана. Энэхүү дагалдах мөнгөн шагналыг тухайн хүнийг шагнуулахаар нэрийг нь дэвшүүлж тодорхойлсон байгууллага олгоно.

5.7. Салбарын тэргүүний ажилтан тэмдэг, үнэмлэх, яамны "Хүндэт жуух бичиг"-ийг үрэгдүүлсэн тохиолдолд нөхөн олгож болно. Нөхөн олгоход дараахь материалыг бүрдүүлнэ.

5.7.1. нөхөн олгож өгөхийг хүссэн өргөдөл;

5.7.2. үрэгдүүлсэн тухай зарлуулсан баримт;

5.8. Энэ журмын 5.7-д заасан баримтыг үндэслэн Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн захиргааны удирдлагын газраас шагналын тэмдэг, үнэмлэхний зардлыг байгууллага, иргэнээс гаргуулж нөхөн олгоно.

Зургаа. Шагналын мэдээллийн сан

6.1. Яам нь шагнагдсан хүмүүсийн цахим мэдээллийн сантай байна.

6.2. Мэдээллийн сангийн бүрдүүлэлт, баяжилт хөдөлгөөнийг Төрийн захиргааны удирдлагын газрын шагнал урамшууллын асуудал хариуцсан мэргэжилтэн хариуцана.

-----oOo-----

Засгийн газрын салбарын "Хууль зүйн албаны тэргүүний ажилтан", "Хүндэт хилчин", "Цагдаагийн алдар", "Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагын тэргүүний ажилтан", "Улсын бүртгэлийн тэргүүний ажилтан", тэмдэг болон Хууль зүйн яамны "Хүндэт жуух бичиг" шагналаар шагнуулах хүний /анкет/ тодорхойлолтын загвар

Овог, нэр

зураг

1. Регистрийн дугаар

2. Хүйс, төрсөн он

3. Иргэншил

4. Боловсрол, мэргэжил

5. Үндсэн захиргаа

6. Хэзээ, хаана, ямар ажил хийж байсан:

7. Одоо хаана ямар ажил эрхэлж байгаа:

8. Улсад ажилласан нийт хугацаа, /жил/ үүнээс тухайн салбарт.....жил, тухайн хөдөлмөрийн хамт олны дотор.....жил

9. Төр засгийн дээд шагналаар хэзээ шагнагдсан /шагналын нэр, он/

10. Бусад ямар шагналаар хэзээ шагнагдсан /салбарын, аймаг, нийслэлийн нэр, он/

11. Шагнуулах гэж буй үндэслэл: /эрхэлсэн ажлын амжилт нь бусдаас ялгарах онцлог, тэдгээрийн үр дүн, бүтээлийн жагсаалт, ажлын чадвар, хариуцлага, санаачлагын талаар тусгана. Ажлын гол үзүүлэлтийг сүүлийн 5 жилээр тооцон гаргах/

12. Шагнуулах шагналын нэр:

13. Албан газар, байгууллагын дарга, захирал, эрхлэгчийн гарын үсэг, тэмдэг.